**ДОРНОД АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

***Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит***

**Аудитын код:** ***ДОА-2021/53/СТА-ТШЗ***


Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775, khaanconsultingaudit@gmail.com



Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ДОА | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт....3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан....10
3. Аудитын тайлан....11
3.1. Ерөнхий зүйл....11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй....11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт....11
3.4. Материаллаг байдал....11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд....12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт....13
3.7. Шилэн дансны мэдээлэл....13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....14
3.9. Аудитын илрүүлэлт....14
Залруулсан алдаа....14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил....14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд....15
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт....15

## 1.Хараат бус аудиторын дүгнэлт

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000. Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 155

танай ________ -ны № ________ -т

БАЯНТҮМЭН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.СУГАРЖАВ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021264

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 37,258,633.33 | 45,268,359.27 |
| 33 | АВЛАГА | 1,220,150.00 | 1,220,150.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,220,150.00 | 1,220,150.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 36,038,483.33 | 44,048,209.27 |
| 354 | Хангамжийн материал | 36,038,483.33 | 44,048,209.27 |
| 35420 | Аж ахуйн материал | 24,089,828.25 | 25,495,968.57 |
| 35460 | Хүнсний материал | - | 1,672,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 8,956,452.70 | 16,880,140.70 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 468,904,438.92 | 503,390,155.66 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 468,904,438.92 | 503,390,155.66 |
| 392 | Биет хөрөнгө | 442,846,438.92 | 477,332,155.66 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 339,589,444.30 | 339,589,444.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (15,054,148.92) | (39,024,292.68) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 49,995,000.00 | 49,995,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | - | (8,332,500.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 84,794,061.92 | 85,997,988.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (67,304,664.16) | (69,954,034.02) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 49,766,189.47 | 65,276,231.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (26,692,711.03) | (23,477,726.91) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 14,600,000.00 | 14,600,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,040,000.00 | 52,576,111.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (275,333.44) | (302,666.68) |
| 39217 | Ном | 10,388,600.78 | 10,388,600.78 |
| 393 | Биет бус хөрөнгө | 26,058,000.00 | 26,058,000.00 |
| 39301 | Програм хангамж | 400,000.00 | 400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (400,000.00) | (400,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 26,058,000.00 | 26,058,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 506,163,072.24 | 548,658,514.93 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 506,163,072.24 | 548,658,514.93 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 506,163,072.24 | 548,658,514.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 133,071,561.88 | 133,071,561.88 |
| 51101 | Өмч: - төрийн | 133,071,561.88 | 133,071,561.88 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (20,912,193.11) | 21,583,249.58 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (20,912,193.11) | (20,912,193.11) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 42,495,442.68 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 394,003,703.47 | 394,003,703.47 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 506,163,072.24 | 548,658,514.93 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **590,053,285.50** | **477,256,598.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **220,808,285.50** | **92,141,298.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 220,808,285.50 | 92,141,298.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 220,808,285.50 | 82,931,470.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 219,288,771.00 | 82,931,470.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй авсан орлого - Бараа | 1,519,514.50 | 9,209,828.32 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **369,245,000.00** | **385,115,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 344,245,000.00 | 359,208,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 344,245,000.00 | 359,208,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 100,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 100,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,000,000.00 | 25,806,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,000,000.00 | 25,806,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **386,980,106.86** | **433,304,325.68** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **386,980,106.86** | **433,304,325.68** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 378,829,073.86 | 417,363,448.23 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 264,124,086.00 | 292,398,775.00 |
| 210101 | Үндсэн цалин | 189,596,540.00 | 216,164,373.00 |
| 210102 | Нэмэгдэл | 50,837,804.00 | 53,573,053.00 |
| 210104 | Урамшуулал | 23,689,742.00 | 22,661,349.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,217,536.00 | 38,712,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,597,432.00 | 24,806,600.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,520,014.00 | 3,476,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,259,038.00 | 2,781,499.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 531,005.00 | 694,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,310,047.00 | 6,952,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,825,475.00 | 17,205,117.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,456,235.00 | 4,806,859.55 |
| 210302 | Түлш, халаалт | 14,809,240.00 | 10,728,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,560,000.00 | 1,670,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,109,400.00 | 7,079,282.38 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,810,600.00 | 1,108,980.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,400,000.00 | 2,358,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 198,800.00 | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,700,000.00 | 403,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 2,808,202.38 |
| **2105** | **Нормативт зардал** | 17,639,970.00 | 10,627,150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 600,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,829,970.00 | 10,027,150.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,000,000.00 | 2,790,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,790,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,080,000.00 | 877,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,900,000.00 | 517,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 29,832,606.86 | 47,673,923.30 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 735,300.00 | 685,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,097,306.86 | 46,988,923.30 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 8,151,033.00 | 15,940,877.45 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,770,000.00 | 5,854,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,770,000.00 | 4,844,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,010,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,174,525.00 | 5,931,482.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,174,525.00 | 5,931,482.45 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 206,508.00 | 4,154,895.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 206,508.00 | 4,154,895.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **203,073,178.64** | **43,952,272.64** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 1,456,829.96 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 1,456,829.96 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (1,456,829.96) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **203.073.178.64** | **42.495.442.68** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **369,245,000.00** | **385,115,300.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **369,245,000.00** | **385,115,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 344,245,000.00 | 359,208,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 344,245,000.00 | 359,208,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 100,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 100,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,000,000.00 | 25,806,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,000,000.00 | 25,806,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **369,245,000.00** | **385,115,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **369,245,000.00** | **385,115,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **361,093,967.00** | **368,355,422.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 264,124,086.00 | 292,398,775.00 |
| 210101 | Үндсэн цалин | 189,596,540.00 | 216,164,373.00 |
| 210102 | Нэмэгдэл | 50,837,804.00 | 53,573,053.00 |
| 210104 | Урамшуулал | 23,689,742.00 | 22,661,349.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 33,217,536.00 | 38,712,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,597,432.00 | 24,806,600.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,520,014.00 | 3,476,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,259,038.00 | 2,781,499.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 531,005.00 | 694,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,310,047.00 | 6,952,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,825,475.00 | 17,075,117.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,456,235.00 | 4,806,859.55 |
| 210302 | Түлш, халаалт | 14,809,240.00 | 10,728,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,560,000.00 | 1,540,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 8,164,400.00 | 4,262,080.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,865,600.00 | 999,980.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,400,000.00 | 2,358,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 198,800.00 | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,700,000.00 | 503,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,029,970.00 | 11,330,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 450,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,829,970.00 | 10,880,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,000,000.00 | 2,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 2,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,080,000.00 | 877,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,900,000.00 | 517,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,652,500.00 | 900,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,652,500.00 | 900,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **8,151,033.00** | **16,759,877.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 6,770,000.00 | 6,673,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,770,000.00 | 5,663,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 1,010,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,174,525.00 | 5,931,482.45 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,174,525.00 | 5,931,482.45 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 206,508.00 | 4,154,895.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 206,508.00 | 4,154,895.00 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 133,071,561.88 | 394,003,703.47 | -20,912,193.11 | 0.00 | 506,163,072.24 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **133,071,561.88** | **394,003,703.47** | **-20,912,193.11** | **0.00** | **506,163,072.24** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **133,071,561.88** | **394,003,703.47** | **-20,912,193.11** | **0.00** | **506,163,072.24** |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **133,071,561.88** | **394,003,703.47** | **-20,912,193.11** | **0.00** | **506,163,072.24** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **133,071,561.88** | **394,003,703.47** | **-20,912,193.11** | **0.00** | **506,163,072.24** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 42,495,442.68 | 0.00 | 42,495,442.68 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **133,071,561.88** | **394,003,703.47** | **21,583,249.57** | **0.00** | **548,658,514.92** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 385,015,300.00 | 374,928,922.55 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 385,015,300.00 | 374,928,922.55 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 377,115,100.00 | 368,255,422.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 292,421,500.00 | 292,398,775.00 |
| 210101 | Үндсэн цалин | 221,600,000.00 | 216,164,373.00 |
| 210102 | Нэмэгдэл | 43,757,200.00 | 53,573,053.00 |
| 210104 | Урамшуулал | 27,064,300.00 | 22,661,349.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 38,712,200.00 | 38,712,200.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27,015,400.00 | 24,806,600.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,339,400.00 | 3,476,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,924,200.00 | 2,781,499.63 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 584,800.00 | 694,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,848,400.00 | 6,952,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,006,600.00 | 17,075,117.55 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,000,000.00 | 4,806,859.55 |
| 210302 | Түлш, халаалт | 15,446,600.00 | 10,728,258.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,560,000.00 | 1,540,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,164,800.00 | 4,162,080.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,000,000.00 | 899,980.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,200,000.00 | 2,358,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 400,000.00 | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,564,800.00 | 503,800.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,850,000.00 | 11,330,250.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 500,000.00 | 450,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,850,000.00 | 10,880,250.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,800,000.00 | 2,800,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,800,000.00 | 2,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,160,000.00 | 877,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хуј | 800,000.00 | 517,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,000,000.00 | 900,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,000,000.00 | 900,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 7,900,200.00 | 6,673,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,900,200.00 | 6,673,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 6,890,200.00 | 5,663,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,010,000.00 | 1,010,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 385,015,300.00 | 374,928,922.55 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 359,208,700.00 | 349,122,322.55 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 25,806,600.00 | 25,806,600.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **100,000.00** | |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **100,000.00** | |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 100,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 100,000.00 | |
| 210401 | Бичиг хэрэг | - | 100,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 100,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 100,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 100,000.00 | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | | |

## 3.Аудитын тайлан

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Т.Сугаржав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 15-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургууль 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 04 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ зөв сайхан ярьж, бичдэг, монгол ёс уламжлалаа танин мэдсэн бүтээлч хүүхдийг төлөвшүүлнэ.
- Монгол Улсын Боловсролын тухай хууль, төрийн холбогдох төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### 3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 433,304.3 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 8,666.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 548,658.5 мянган төгрөгөөр буюу 8.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 0 | |
| Авлага | 1,220.2 | 1,220.2 | - |
| Урьдчилгаа | 0 | 0 | |
| Бараа материал | 36,038.5 | 44,048.2 | 8,009.7 |
| Үндсэн хөрөнгө | 468,904.4 | 503,390.1 | 34,485.7 |
| **Нийт хөрөнгө** | **506,163.1** | **548,658.5** | **42,495.4** |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 506,163.1 | 548,658.5 | 42,495.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **506,163.1** | **548,658.5** | **42,495.4** |

Авлагын үлдэгдэл 1,220.2 мянган төгрөг байгаа нь 2005, 2013 онд үүссэн төлөгдөх хугацаа нь тодорхойгүй авлагууд байна.

Бараа материалын данс 44,048.2 мянган төгрөг болж 8,009.7 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй болон шилжүүлэн авсан хангамжийн материалаас нь шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс нь 503,390.1 мянган төгрөг болж 34,485.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө оруулалтын ажил 82,391.4 мянган төгрөгөөр хийгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс 16,681.3 мянган төгрөгийн хөрөнгийг актлаж данснаас хассан байна.

Өр төлбөр данс үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо данс 548,658.5 мянган төгрөг болж, 42,495.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны үр дүнгээс шалтгаалжээ.

Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 112,796.7 мянган төгрөгөөр буюу 19.1 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 46,324.2 мянган төгрөгөөр буюу 11.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хангамжийн материалын зардал бараа үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь цалин нэмэгдсэн, бараа материал зарлагадсан зэргээс шалтгаалсан байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 456,667.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 456,667.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 71,651.9 мянган төгрөгөөр бууруулж 385,015.3 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 385,015.3 мянган төгрөгийн төсөв батлалснаас 339,458.5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 45,556.8 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 339,458.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 45,556.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 385,015.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 374,929.0 мянган төгрөгийг зарцуулж 10,086.3 мянган төгрөгийг улс, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 374,929.0 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь урсгал засварын зардлыг 5,931.4 мянган төгрөгөөр, үдийн цай болон хоолны 4,154.9 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 100.0 мянган төгрөгийн дэмжлэг авч, бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

## 3.7. ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээлэл байршуулахаас хугацаандаа оруулсан 144, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 гүйлгээний 25,142.1 мянган төгрөг, батлагдсан төсөв 385,015.3 мянган төгрөг, төсвийн төсөл 456,667.2 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 63,008.1 мянган төгрөг, аудитын дүгнэлт, тайлан, тушаал шийдвэртэй холбоотой нийт 7 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан байна.

## 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,177.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 35,800.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагыг 100 хувьтай биелүүлсэн байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 2,177.2 | 2 | 2,177.2 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Албан шаардлага | 3 | 35,800.0 | 3 | 35,800.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| Нийт дүн | 5 | 37,977.2 | 5 | 37,977.2 | 0.0 | 0.0 | 100.0 |

## 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26,762.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 26,314.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 147.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 300.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулллаа. Үүнд:

Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 10,086.3 мянган төгрөгийг оруулаагүй бүртгэснийг залруулсан.

Үндсэн хөрөнгө, бараа материалын тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн бүртгэл 11,228.6 мянган төгрөгийг залруулсан.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулаагүй 447.2 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс сахилгын шийтгэлтэй албан хаагчдад олгосон 147.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан 300.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1.Сахилгын шийтгэлтэй ажилтан, албан хаагчдад шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 147.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.6 дахь заалт “Төрийн жинхэнэ албан хаагч сахилгын шийтгэл ногдуулсан өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалтуудтай нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт тогтоов.

2. Тээвэр шатахууны зардлаас 300.0 мянган төгрөгөөр төлбөрийн акт төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 ”Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;”, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “Төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу

хэрэгжүүлж, тайлагнах" гэсэн заалтад нийцэхгүй санхүүгийн тайлангийн хэмжилт, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

## 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй

**Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Аудитын код: |
|---|---|---|
| 2020 | ***Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*** | ДОА-2021/53/СТА-ТШ3 |

| Шалгагдсан байгууллагын нэр: | Баянтүмэн сумын Ерөнхий боловсролын сургууль | Мянган төгрөгөөр |
|---|---|---|

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Сахилгын шийтгэлтэй ажилтан, албан хаагчдад шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй байхад 147.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон | 147.2 | Төлбөрийн акт тогтоох | Захирал, нягтлан бодогч | Т.Сугаржав Ч.Ариундэлгэр |
| 2 | Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 22 гүйлгээний 25,142.1 мянган төгрөг, батлагдсан төсөв 385,015.3 мянган төгрөг, төсвийн төсөл 456,667.2 мянган төгрөг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө 63,008.1 мянган төгрөг, аудитын дүгнэлт, тайлан, тушаал шийдвэртэй холбоотой нийт 7 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроож байршуулсан | | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Т.Сугаржав Ч.Ариундэлгэр |
| 3 | Тээвэр шатахууны зардлаас 300.0 мянган төгрөгөөр төлбөрийн акт төлсөн байна. | 300.0 | Албан шаардлага өгөх | Захирал, нягтлан бодогч | Т.Сугаржав Ч.Ариундэлгэр |
| **ДҮН** | | **447.2** | | | |